


Газрын даргын 2024 оны 07 дугаар
сарын 01 -ний өдрийн 132 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хүсэлт гаргагч:...../Итгэмжлэгч/.....
Холбоо барих утасны дугаар:.....
Төлөвлөж буй барилга байгууламжийн нэр:.....
Төлөвлөж буй барилга байгууламжийн байршил:.....

Тайлбар:

- Барилгын тухай хуулийн 20.2-т заасан барилга байгууламж барих барилгын ажлын зөвшөөрлийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно. /УИХ 2022.04.22. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай/
- Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1-т заасан зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна гэж заасны дагуу холбогдох материалуудыг скайнердаж PDF өргөтгөлтэйгөөр цаасан болон цахим хэлбэрээр BAZG@uda.ub.gov.mn хаягаар ирүүлнэ үү. PDF өргөтгөлтэй файлын хэмжээ 5MB-ээс доош байна.
- Материалын бүрдлийг PDF өргөтгөлтэй цахим хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгогдохгүй болохыг анхаарна уу.

ДӨРӨВ. БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

№	Үндэслэл, хуулийн заалт	Баримт бичгийн жагсаалт, тайлбар	Бүрдэл
1.	Барилгын тухай хууль 28.2, 37.1 Барилгын ажлын захиалагч нь барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.	Захиалагчаас барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дурдсан өргөдөл, албан бичиг ирүүлэх. Жич: Хүсэлтийг зөвхөн захиалагчаас ирүүлэх.	
2.	Барилгын тухай хууль 28.3. Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгээс гадна зураг төсөл боловсруулсан болон барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хавсаргана.	Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар. Жич: Хугацаа хүчин төгөлдөр байх.	

3.	Барилгын ажил гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээг цуцалсан тухай шийдвэр	Барилгын ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан тухай баримт бичгийн эх хувь (барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч солигдсон тохиолдолд ирүүлэх)	
4.	Зураг төсөлд орсон томоохон өөрчлөлттэй холбоотой баримт бичиг	Барилгын зориулалт өөрчлөгдсөнөөр батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгаварт өөрчлөлт оруулсан баримт бичгийн эх хувь. Жич: Барилгын үндсэн бүтээцэд өөрчлөлт ороогүй байх	

Зөвлөмж:

1. Зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээд нь Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ гарсны дараа **Тэмдэгтийн хураамж 20.000₮-ийг Төрийн сан 100200051054** дугаар дансанд тушаана уу. **Гүйлгээний утга: Иргэн бол заавал регистрийн дугаар, цахим хаяг, аж ахуй нэгж бол байгууллагын регистрийн дугаар, цахим хаяг бичих.**
2. Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 4.5 "Захиалагч барилгын ажлын явцад дараах өөрчлөлт гарсан тохиолдолд Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрд нь мэдэгдэнэ" гэж заасны дагуу доорх өөрчлөлт орсон бол Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулна. Үүнд:
 - Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон;
 - Гүйцэтгэгч, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдсөн;
 - Гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;
 - Барилга байгууламжийн үндсэн бүтээцэд өөрчлөлт оруулж, зураг төсөл өөрчлөгдсөн;
 - Дуусаагүй барилга, байгууламжийг хамгаалалтын горимд оруулах болон уг хугацаа дуусгавар болсон.

Хүсэлт хүлээн авсан мэргэжилтэн//

нэр

..... оны сарын өдөр